



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/905

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.1, Монгол Улсын Засгийн газрын "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 2020 оны 207 дугаар тогтоол тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн нас, бие бялдрын онцлог, өсөлт хөгжилтийн хэрэгцээнд тохирсон, хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодисын хэрэгцээг хангасан, эрүүл, аюулгүй хоол ундаа бэлтгэх, хоолны цэсийг оновчтой болгож түгээн дэлгэрүүлэх, тогооч нарын мэргэжлийн ур чадварын анхдугаар уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	М.Анхбаяр	(Засаг даргын орлогч)
Гишүүд:	Б.Мөнхжаргал	(Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)
	Ц.Уранбямба	(Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)
	Ю.Цолмон	(Политехник коллежийн захирал)
	А.Ууганбаяр	(Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын дарга)
	Д.Энхтуяа	(Дундговь аймгийн тогоочдын "Арга билэг" холбооны дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Мөнхзул	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Хүүхдийн шимт тэжээлт хоолны анхдугаар уралдааныг 2023 оны 5 дугаар сард багтаан үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4823100698